

С.Гомбо

*МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш,
Социологийн ухааны доктор*

Ц.Болд

МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш,

ЯПОН ОРОН, ЯПОНЧУУДЫН ТАЛААРХ МОНГОЛЫН ОЛОН НИЙТИЙН САНАА БОДОЛ

*Монгол Японы хооронд дипломат харилцааа
тогтоосны 40 жилийн ойд*

Энэхүү бэсрэг өгүүллийг, тус тэнхмээс эрхлэн (зохиогчийн удирдлагаар) Японы ЭСЯ-ны захиалгаар одоогоос долоон жилийн өмнө 2004 онд Улаанбаатар, Эрдэнэт хот болон Дорнод, Өмнөговь, Ховд, Сэлэнгэ аймгийн төвийн 2000-гаад хүн амын дунд хийсэн судалгааны материалд тулгуурлан, зах зээлийн харилцаанд шилжиж байх үед гадаадын улс орнуудын талаарх Монголчууд бидний үнэлэмж, үзэл бодолд багагүй өөрчлөлт гарч байгааг харуулах, судалж тогтоосноо олон нийтэд хүргэх зорилгоор бичлээ⁶¹.

Монголчууд бид гадаад өмөг түшигээ ЗХУ (хуучин нэрээр) болон эдийн засгийн харилцан туслалцах Зөвлөлийн орнуудыг гэж үзэж, тэдэнтэй хамтран ажиллаж, тэдгээр орны хөгжлийн түвшингээр л аливаа зүйлийг харьцуулан үнэлдэг байсан цаг саяхан. Энэхүү явцуухан, хязгаарлагдмал үзэл бодлоосоо салж дэлхийн бусад орнуудтай өргөн хүрээтэй, нээлттэй харьцаж “нүд тайлж” байх үеийн үнэлэмж, санал бодлыг энэ судалгааны материал илэрхийлж буй учраас ихээхэн сонирхол татахуйц юм. Гадаадын улс орнуудын талаарх олон нийтийн санаа бодолд гарч буй өөрчлөлт нь зах зээлийн харилцааны үеийн Монголын нийгмийн өнөөгийн төрхийг ерөнхийд нь тусгаж байна гэж үзэж болно.

Монголчуудын сонирхлыг тухайн үед хамгийн ихээр татаж байсан гадаадын орнуудын талаар дараах цувааг үүсгэж болохыг уг судалгаа харуулсан юм. Үүнд:

1. АНУ (27,0:41,8)
2. Япон (21,5:33,4)
3. Өмнөд Солонгос (15,4:23,9)
4. Герман (6,7:10,4)
5. Франц (5,4:8,4)
6. Англи (5,2:8,1)
7. ОХУ (4,8:7,5)
8. Хятад (3,7:5,8)
9. Хойд Солонгос (0,5:0,8) орж байна.⁶²

Судалгаанд хамрагдсан таван хүн тутмын хоёр нь АНУ-ыг, гурван хүн тутмын нэг нь Японыг, дөрвөн хүн тутмын нэг нь Солонгосыг нэрлэж байсан учраас эдгээр орнууд олон нийтийн санаа бодолд голлох орон зайг эзэлж байна гэж дүгнэж болно. Энэ үзүүлэлт судлагдагсдын нас, боловсролын байдлаас тун бага хамааралтай, өөрөөр хэлбэл аль ч насныхны хувьд төдийгүй төрийн албан хаагч, эмч, багш, хэн ч байлаа гэсэн дээрх гурван орныг хамгийн их сэтгэл татдаг гэж хариулсан давтамж өндөртэй байлаа. (хүснэгт.№1-ээс үзнэ үү)

Өнөөгийн Монголчуудын сонирхлыг татдаг гадаад орнуудын дотроос заавал очиж үзэх юмсан гэж боддог улсуудын хувьд мөн л АНУ (29,3%:40,8), Япон (22,4%:31,3%), Өмнөд

⁶¹ Аливаа ой тэмдэглэх ажиллагааны хүрээнд өнгөрсөн үйл явдал, ажлын арга туршлагаа сэргээн санах утга санаа хамаарагддаг учраас нийтэд гараагүй энэ судалгааны товч дүнг дэлгэн тавив.

⁶² Улсын нэрний дараах хаалтанд байгаа хоёр хувийн эхнийх нь дан, дараагийнх нь давхардсан (зарим хүмүүс хоёроос гурван улсыг нэрлэсэн тохиолдолд бодсон хувь) тоогоор гарсан үзүүлэлт юм.

Солонгос (11,4%:15,9%), Франц (10,2%:14,3%) дараа нь Герман, Англи оржээ. Гэтэл тэр үеэс 12 жилийн өмнө (1992 онд) хийсэн судалгаагаар АНУ 3-рт, Япон 1-рт, Өмнөд Солонгос 6-рт эрэмбэлэгдэж байсан юм байна.⁶³ Америк, Японыг үзэх сонирхолтой хүмүүсийн дотор дээд боловсролтой, дундаж насныхан илүү өндөр хувьтай байна. Тухайлбал дээд боловсролтой хүмүүсийн 45,6 хувь нь Японыг үзэх сонирхолтой гэсэн хариулт өгчээ.

**Монголчуудын сонирхлыг татдаг
гадаадын орнууд (давхардсан тоогоор бодсон хувиар)**

№	Улсын нэр	Нэгдсэн дүнгээс	Нас			Боловсрол				Сэхээтний зарим бүлгээр		
			30 хүртэл	30-59	60-аас дээш	Дээд	Бүрэн дунд	Бүрэн бус дунд	Бага	Төрийн албан хаагч	Багш нар	Эмч нар
1	АНУ	41,8	40,3	44,2	32,0	48,9	35,9	39,4	37,0	47,6	48,1	44,6
2	Япон	33,4	28,7	37,1	36,1	34,9	30,6	24,9	40,7	31,7	43,8	46,4
3	Солонгос	23,9	26,0	23,0	15,5	18,1	26,8	37,6	33,3	13,2	21,6	23,2
4	Герман	10,4	10,2	10,7	8,2	10,8	10,4	8,3	7,4	9,5	10,5	10,7
5	Франц	8,4	8,9	8,6	2,1	10,6	8,1	5,5	-	12,2	9,9	10,7
6	Англи	8,1	9,1	7,6	4,1	9,5	7,4	6,4	3,7	8,5	8,6	5,4
7	ОХУ	7,5	5,8	6,7	29,9	6,5	6,9	11,9	22,2	7,4	6,8	5,4
8	БНХАУ	5,8	4,7	5,9	13,4	5,4	5,6	11,0	11,1	1,6	4,9	5,4

Монголчуудын сонирхлыг татдаг, очиж үзэх хүсэлтэй гэсэн орнуудын дотор ОХУ болон БНХАУ (долоо, наймдугаарт) сүүлийн байруудад орж байгааг юуны өмнө эдгээр улс орны талаарх мэдээлэл хангалттай, бараа таваар нь элбэг байдаг төдийгүй, тэдний нэлээд нь урьд өмнө нь очиж нүдээр үзэж байсантай холбон тайлбарлаж болох юм. Харин өөрийн орныг цаашдаа ямар улстай хамгийн ойр дотно байгаасай гэж үздэг талаар дээрхээс арай өөр бодолтой байдаг нь судалгаагаар харагдлаа. Энэ талаар АНУ-тай гэхээсээ Японтой ойр дотно харьцаатай байх нь ашигтай гэсэн үзэл бодол үл ялиг давамгайлж байна. Энэ нь Монгол-Японы эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцаа улам гүнзгийрч, ялангуяа японы техник эдийн засгийн хандив тусламж нэмэгдэж байгаагийн зэрэгцээгээр эдгээр орны төрийн ба төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа улам өргөжин тэдгээр нь жирийн хүмүүсийн ахуй амьдралд бодитойгоор мэдрэгдэж байгаагийн үр дүн гэж үзэх үндэстэй юм. Мөн газар нутгийн ойр дөт байдал ч нөлөөлсөн байж болно.

Ойр дотно харьцаатай байвал зохистой орны тоонд ОХУ гуравдугаарт орж байгааг хуучин найрамдалт харилцаатай, олон жил нөхөрлөж байсан түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагаанаас гадна орос хүний зан ааш, бараа таваарынх нь чанар чансааг мэддэг, байсантай холбон тайлбарлаж болно.

Монголд идэвхитэй зээл, тусламж үзүүлж буй улс, байгууллагыг нэрлэнэ үү гэсэн асуудлыг аль ч насныхан нэгд, Япон (28.2%:46.6%), хоёрт, ОХУ (12.5%:20.6%)-ыг, олон улсын байгууллагаас Азийн хөгжлийн банк (22,4:39,9)-ыг тус тус нэрлэсэн байна.

Өөрийн орныг гадаадын ямар улстай цаашдаа ойр дотно харилцаатай байгаасай гэж үздэг санал бодол аймаг, хотуудын хувьд бага зэрэг ялгаа ажиглагдана. Жишээлбэл: Улаанбаатар хотынхны хувьд 1. АНУ(38,8%), 2. Япон (32,4%), 3. ОХУ (26,5%) гэсэн сонголт хийсэн байхад Өмнөговь, Дорнод, Сэлэнгэ, Эрдэнэтээс судалгаанд хамрагдагсад 1-рт Японыг, 2-рт АНУ-ыг, 3-рт ОХУ-ыг гэсэн саналтай байлаа.

Япон улс танд хэр зэрэг дотно санагддаг вэ? гэсэн бидний судалгааны тандах асуултанд судлагдагсдын 31,6 хувь нь (632 хүн) буюу ойролцоогоор гурван хүний нэг нь их ойр дотно санагддаг, 40,7 хувь нь (814 хүн) буюу тавны хоёр нь дунд зэрэг л гэж, өөрөөр хэлбэл нэг их ойр ч биш, бас нэг их хол ч биш бодогддог гэсэн хариулт өгсөн байна. Харин судлагдагсдын (384 хүн) 19,2 хувь нь буюу таван хүн тутмын нэг нь Япон орныг нэг их ойр дотно санагддаггүй гэж үздэг ажээ. Энэ үзүүлэлт нас, боловсролоор ялгаа бага харин аймаг, хотуудаар бага зэрэг

⁶³ МУИС, Японы “Асахи” сонины газартай хамтран Монгол Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойд зориулж хот, хөдөөгийн 1200 хүнийг хамарсан санал асуулгын судалгаа хийсэн юм. (Судалгааны дүн “Ардын эрх сонины 1992 оны 2-ны №180-д нийтлэгдсэн.)

өөрчлөлтийг ажиглаж болох юм. Япон орон ойр дотно санагддаг гэсэн үзүүлэлт Эрдэнэт (43,1), Өмнөговь (38,1), Сэлэнгэд (36,1), дунджаас дээгүүр, Ховд (25,9%), Улаанбаатар (28,8%)-т дунджаас арай доогуур байна.

Монгол-Японы нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын харилцааны өнөөгийн түвшинг аль ч насныхан ялгаагүй өндрөөр үнэлж байгаа бөгөөд судлагдсан залуучуудын 60,0%, дундаж насныхны 68,3%, ахмадуудын 67,6% нь цаашдаа ч улам сайжирна гэж үзэж байна.

Япон гэж сонсуут л юу юуны түрүүнд сумо бөх (25,0%:36,5%), 2-рт электрон бараа (18,8%:27,5%), 3-рт эдийн засгийн өндөр хөгжил буюу том гүрэн (18,4%:26,8%) л санаанд ордог гэсэн хариулт зонхилж байна.⁶⁴ Мэдээж, тухайн үед Монгол бөхчүүд мэргэжлийн сумод тогтмол амжилттай сайн барилдаж эхэлсэн, анзаарагдахуйц амжилт гаргаж эхэлсэн байснаас манайхан хот, хөдөөгүй, хөгшин залуугүй нийтээр сумог сонирхон үздэг болсонтой холбоотой. Монголчууд сумог зүгээр нэг хөндлөнгийн сонирхогчийн сэтгэгдлээр биш, түүний нарийн дүрэм журам, мэх бүрийн япон нэр, онцлогийг хүртэл мэдэрч үздэг учраас тэдний сэтгэл санаанд гүнзгий хоногшсон нь зүйн хэрэг юм. Нөгөө талаар бөхийн энэ барилдаан манайхан шиг нутаг нугынхнаа, найз нөхдөө гэхгүй маш шударга, ямар нэг “найраа” үгүй харагддаг нь Монголчуудын сэтгэлийг ихэл татдаг төдийгүй энэ нь цаад утгаараа Япон хүний мөс чанарт шударга ёс нэвт шингэсэн байдаг юм байна гэсэн ойлголтыг ч Монгол хүмүүст өгдөгтэй холбон тайлбарлаж болох юм.

Япон гэхлээр ганцхан сумогоос өөр Монголчуудын санаа бодолд ордог зүйл байдаггүй юм уу гэвэл огтхон ч тийм бишээ. Энэ улсын нэрийг сонсонгуут эдийн засгийн жинхэн өндөр хөгжил, том гүрэн эсвэл цахилгаан ба электрон бараа таваар, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл санаанд ордог гэж өнөөгийн Монголчууд үзэж буйг өмнө дурьдсан. Японы цахилгаан, электрон бараа бодогддог гэсэн үзүүлэлтийг нас ба боловсролын түвшинтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт нь 30-59 насныханд, боловсролын хувьд дээд, тусгай мэргэжлийн ба бүрэн дунд боловсролтой хүмүүсийн дотор байлаа. Энэ нь Японы дээрх бүтээгдэхүүн эдгээр хүмүүсийн ахуй амьдралд бусдаас илүүтэй ашиглагддагтай холбоотой байж болох юм. Харин Японыг эдийн засгийн өндөр хөгжилтэй том гүрэн гэж үздэг хүмүүс аль ч насны бүлэг, боловсролын хувьд жигдхэн өндөр үзүүлэлттэй байна. Энэ гурван үзүүлэлтийн дараагаар 4-рт буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, 5-рт Японы автомашин бодогддог гэсэн хариултыг өгчээ.

Дээрх субъектив үзүүлэлтүүд Японы чухам ямар талыг хамгийн сайн мэддэг вэ? гэсэн өөр асуултын хариулттай нийцэж байгаа нь уг мэдээллийн багтай, найдвартай байдлын илэрхийлэл гэж үзэж болно. Тухайлбаас судалгаанд хамрагдагсад энэ оронд үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүнийг (29,9%:35,8%), шинжлэх ухаан техникийн ололтыг (17,0%:20,4%), биеийн тамир, спортыг (14,3%:17,2%), эдийн засгийн хамтын ажиллагааг (13,8%:16,5%) илүүтэй сайн мэддэг гэсэн хариултыг өгсөн нь дээрхийн баталгаа юм⁶⁵.

Одоо Монголчууд Япон хүмүүсийн бусдаас ялгарах онцлогийг хэрхэн үнэлдэг талаар авч үзье. Өнөөгийн Монголчууд Япон хүнийг маш их хөдөлмөрч (32,3%), харилцааны өндөр соёлтой (17,0%), дуулгавартай (13,7%), бүтээлч санаачлагатай нарийн тооцоотой (12,2%) гэсэн онцлогуудыг бусдаас ялгарах давуу талууд гэж үзэж байна. Энэ үзүүлэлт судлагдагсдын нас, боловсрол төдийгүй сэхээтний зарим бүлгүүдийн (албан хаагч, эмч, багш) хувьд ижил хэмтэй байлаа. Өөрөөр хэлбэл, тэднийг их ажилсаг, харилцааны өндөр соёлтой, бүтээлч, санаачлагатай мөртөө дуулгавартай хүмүүс гэж үздэг үзэл бодол өндөр (бусдыг бодвол) хувьтай байна. Харин тэднийг ихэмсэг дээрэлхүү ааш араншинтай (4,4%), битүү далд муу санаатай, шударга бус зантай (2,3%), бусдынхаа төлөө санаа тавьдаггүй (4,7%) онцлогтой хүмүүс гэж Монголчууд үздэггүй гэдгийг манай судалгааны баримт харуулж байна. Ийм учраас Япон улсыг ойлгомжгүй, сэрэмжилбэл зохих, европ, америк загвартай эсвэл дайнч улс гэж үздэггүй харин эдийн засаг, техникийн өндөр хөгжилтэй (75,9%), баялаг өв уламжлалаа хадгалсан (27,2%), энх тайвныг эрхэмлэсэн (12,8%), үзэсгэлэнтэй сайхан байгальтай (20,4%) орон гэсэн төсөөлөл ихэнх хүмүүст байдаг байна. Энэ нь мөн тэдний нас, боловсрол зэрэг нийгэм хүн ам зүйн ялгаанаас ч үл хамааралтай ажээ.

Монгол-Японы хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаа (буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл зэрэг) болон эдийн засаг, соёл, улс төрийн харилцааны өнөөгийн түвшинд ерөнхийдөө сэтгэл ханамжтай байдгийг дээр өгүүлсэн. Гэхдээ улс төрийн харилцааг бодвол эдийн засгийн хамтын ажиллагаа болон соёл, спортын харилцаанд илүү үнэлэлт өгчээ.

⁶⁴ Хаалтанд буй эхний хувь нь дан, дараагийнх нь давхардсан (нэг хүний 2,3 сонгон орсон) хувь болно.

⁶⁵ Эхнийх нь дан дараах хувь нь давхардсан үзүүлэлт юм.

Тухайлбал, эдийн засгийн харилцааг 32,4 хувь нь, соёл спортын харилцааг мөн 32,4 хувь, улс төрийн харилцааг 22,5 хувь нь тус тус маш сайн гэсэн үнэлгээ өгчээ. Гэхдээ энд нэг онцлох зүйл нь улс төрийн харилцааны түвшинг төрийн албан хаагчид, эмч нар ерөнхийдөө гайгүй гэсэн үнэлэмжийг түлхүү (47,5-50,0%) өгсөн байна.

Япон, Монголын харилцааг судалгаанд хамрагдагсдын 1293 нь буюу 64,7 хувь цаашдаа улам сайжирна, 6,4 хувь өөрчлөгдөхгүй, 1,0 хувь муудна, 548 хүн буюу 27,4 хувь нь сайн мэдэхгүй гэж хариулжээ. Энэ бол үндсэндээ Монголчуудын гурван хүн тутмын хоёр нь улам сайжирна, (нэг нь мэдэхгүй) гэсэн хариулт юм. Хоёр орны харилцааг улам сайжирна гэсэн хариултыг ямар хүмүүс голлон өгч буйг сонирхвол төрийн албан хаагчид (71,9%), дээд боловсролтой хүмүүс (70,9%), насны хувьд бол дундаж ба ахмад насныхан бусдаас илүү үнэлсэн байна.

Япон хүнд болон энэ улс оронд Монголчууд хэр зэрэг итгэлтэй байдгийг тодруулах нь санал асуулгын нэгэн зорилго байсан юм. Судалгаа хийх үед оролцогчдын 14,1 хувь нь энэ улсад бүрэн итгэж болно, 35,6 хувь нь ер нь итгэж болох юм, 31,7 хувь нь зарим талаар итгэж болно гэсэн хариулт өгч байсан. Энэхүү итгэлийн уг үндэс, суурь нь хоёр орны техник эдийн засгийн хамтын ажиллагааны үр өгөөжтэй шууд холбоотой байв. Бидний асуулганд юуг үндэслэн тухайн оронд итгэл өгч байгааг шалгах асуулт байсан бөгөөд судлагдагсдын 29,3 хувь нь 2 орны эдийн засгийн хэлхээ холбооноос, 45,2 хувь нь техник эдийн засгийн хамтын ажиллагаанаас хамааралтайгаар дээрх хариултыг өгсөн байлаа. Үүнтэй холбоотой өөр нэгэн сонирхол татахуйц баримт бол Монгол, Япон хүмүүс хэл, ёс заншлын ялгаатай атлаа бие биеэ хэр зэрэг ойлголцдог вэ? гэсэн “түнших” асуултанд судлагдагсдын 15,2 хувь нь сайтар ойлголцдог, 74,6 хувь нь ерөнхийдөө ойлголцдог гэсэн хариулт өгсөн нь анхаарал татах үзүүлэлт юм. Япон, Монгол хүмүүс яагаад бие биеэ ойлголцдог гэж боддог вэ? гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан хүмүүсийн 1037 нь буюу 51,9 хувь нь хоёр орны харилцаа сайнаас, 292 нь буюу 14,6 хувь нь соёл, ёс заншил төстэйгөөс, 244 нь буюу 12,2 хувь нь гадаад төрх ойролцоогоос, 116 нь буюу 5,8 хувь нь шашин шүтлэг нэгтэйгээс харилцан бие биеэ ойлголцдог гэсэн хариулт өгсөн байх юм.

Япон орныг дээр дурьдсанчлан сэтгэл булаам үзэсгэлэнтэй байгаль орчинтой, техник технологи өндөр хөгжсөн, аюулгүй амьдрах орчин бүрдсэн, боловсон соёл зан заншилтай улс учраас судлагдагсдын 54,1 хувь нь заавал очиж үзнэ гэсэн бодолтой байдаг байна.

Япон орны талаарх дээрх бүх нааштай үзэл бодол тэдний япон хэл сурах хүсэл эрмэлзэлтэй шууд холбоотой байна. Энэ нь Япон орны хөгжил цэцэглэлтийг өнгөцхөн сонирхсон санаархал биш гэдгийн нотолгоо юм.

Одоогоос 10 гаруй жилийн өмнө Японы судалгааны төвийн захиалгаар тус тэнхмээс эрхлэн хийсэн гадаад хэлний тархалтын судалгаанд хамрагдагсдын 6,0 хувь нь япон хэлийг сурч байгаа буюу сурч байсан⁶⁶ гэсэн хариулт өгч байсан бол уг үзүүлэлт энэ удаагийн судалгаагаар даруй 13,7 хувь болж 2 илүү дахин өссөн үзүүлэлт гарчээ. Тэдний 23,3 хувь нь их, дээд сургуулиар, 7,3 хувь нь ЕБДС-иар 20,7 хувь нь хэлний дамжаа курсээр, 36,4 хувь нь бие даан суралцдаг байна. Харин яагаад япон хэлийг сурах болсон шалтгааны тухайд гэвэл ирээдүйд япон хэл сурах гэж (16,7%), цаашдаа ажилд ороход хэрэгтэй гэж (15,0%), уг хэлийг харь хэлний хувьд сонирхсоноос (19,0%), нийгэм, улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан технологийн мэдлэг олох гэж (19,7%), японы соёлтой танилцах гэж (13,2%) гэсэн хариултууд зонхилж байна. Цаашид ч япон хэлийг үзэх сонирхолтой хүмүүс судлагдагсдын 55,6 хувийг эзэлж байв. Энэ бүхнийг Монголчуудын дунд япон хэлний нэр хүнд ихээхэн өсч байгаагийн нотолгоо гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Япон орны талаарх Монголчуудын санаа бодол ийнхүү эерэгээр огцом өөрчлөгдөж байгаа нь дээр дурьдсанчлан хоёр орны улс төр, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа ердийн хүмүүст мэдрэгдэхүйцээр бодит амьдралд нөлөөлж байгаатай холбоотой. Төр засгийн удирдлагын айлчлал, Засгийн газар хоорондын буцалтгүй зээл тусламж өсөн нэмэгдэж байна. Манай орны нийгэм эдийн засгийн хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд төрийн ба төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа ихээхэн хувь нэмэр болж байна. Ийм учраас ч судалгаанд оролцогсдын 58,9 хувь нь Японы зээл, тусламж манай орны хөгжил цэцэглэлтэнд онцгой үүрэг гүйцэтгэдэг гэсэн хариулт өгчээ. Эдгээр тусламж нь Монголын ялангуяа боловсролын (26,2%), эрүүл мэндийн (22,8%), дэд бүтцийн (18,3%) салбарыг хөгжүүлэхэд болон байгалийн гамшгийг арилгахад (11,4%) илүү нөлөөлдөг гэж үзэж байна. Цаашид ч

⁶⁶ “Манай Монгол” сэтгүүл. 2000.№01(05)

эмнэлэг, эрүүл мэнд, дэд бүтэц, боловсрол, эрчим хүч, байгаль орчин, мэдээлэл харилцааны салбарт Японы тусламж урьдын адил шаардлагатай байгааг судалгааны дүн харууллаа.

Монголд тусалдаг улс орон, байгууллагыг дурьдахдаа: 1-д Япон (28.2:46,6%), 2-т Азийн хөгжлийн банк (24.2:39,3%), 3-д ОХУ (12,5:20,6%), 4-т Дэлхийн банк (7.7:12,8%), 5-д Японы ТББ (6.7%:11.0%)-уудыг нэрлэжээ. Яагаад гэвэл эдгээр байгууллага, улс орны тусламжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилдаг (33,5%), тусламж нь бодитой (30,5%) биетэй зүйл байдаг, цар хүрээ нь ч их (15,7%), өргөн байдаг гэж үздэгээс дээрх хариултыг өгч байгаа ажээ.

Монголд хамгийн их тусалж байгаа улс орон гэхэд Япон, ОХУ хоёрт бусдаас арай илүү үнэлэлт өгсөн байна. Тухайлбал, Японыг гэж үзэж байгаа хүмүүсийн тоо АНУ, БНХАУ-ыг гэснээс 6,3 дахин, Өмнөд Солонгосынхоос 5,9 дахин, ОХУ-ыг гэж өгсөн хүний тоо АНУ, БНХАУ-ынхаас 2,8 дахин, Өмнөд Солонгосоос 2,6 дахин тус тус илүү байсан юм. Гадаад улс орны талаар Монголчуудын өргөн олны санал бодолд гарч буй өөрчлөлт 2004 оны байдлаар иймэрхүү дүр төрхтэй байлаа.

Мөн тэр үед Монгол-Японы харилцаа, хамтын ажиллагааны хэтийн төлөвийн талаарх Монголын сэхээтнүүдийн санал бодлыг тандан судалсан дүнгээс товчхон авч үзье.

Судалгаанд оролцсон сэхээтнүүдээс Монгол-Япон улс харилцан бие биенийхээ талаар баримталбал зохих байр суурь болон цаашдын хамтын ажиллагааны салбарыг хэрхэн үнэлж байгааг харьцуулсан байна.

- ❖ Судалгааны дүнгээс харахад хоёр улсын харилцааг улам сайжруулахын тулд эдийн засгийн салбар дахь хэлхээ холбоогоо улам өргөжүүлэх (51,9%), хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжтай холбогдсон харилцаагаа хөгжүүлэх (28,7%), улс төр, аюулгүй байдлын чиглэлээр хамтын ажиллагаагаа хөгжүүлэх (11,2%) байр суурийг Японы зүгээс баримтлах нь зөв гэсэн саналыг судалгаанд хамрагдсан сэхээтнүүд өгсөн байна.
- ❖ Харин манай улсын хувьд мөн л эдийн засгийн харилцаагаа түлхүү анхаарч өргөжүүлэх нь зүйтэй (54,0%), Япон улсын тусламжаас гарч бие даан хөл дээрээ босох нь зөв (16,2%), улс төр, аюулгүй байдлын асуудлаар (15,5%) хамтран ажиллах байр суурийг илүүтэй баримтлах ёстой гэжээ. Үүнээс үзэхэд сэхээтнүүдийн дийлэнх нь хоёр улсын хоорондын эдийн засгийн хэлхээ холбоог чухалчлан үзэж, энэ чиглэлээр хамтын ажиллагаанд ихээхэн найдвар тавьж байгаа нь тодорхой байв. Гэхдээ энд хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийг хөгжүүлэх нь зөв гэсэн санал эдийн засгийн хэлхээ, холбоогоо өргөжүүлэх нь зөв гэж үзсэн хүмүүсээс даруй 23,2%-иар бага байгааг дан ганц гадны зээл тусламжаар улс орон хөгжихгүй гэдгийг ухамсарлан ойлгосон, бэлэнчлэх бусдаас хишиг горьдсон гараа хумхин сууж болохгүй гэдэг сэтгэлгээ нийгэмд тархаж буйг харуулах эерэг үзүүлэлт байгаасай гэж бодож байна.
- ❖ Монгол-Японы хамтран ажиллах салбарын тухайд шинжлэх ухаан, техникийн хөгжил (26,9%), Ази тивийн хамтын ажиллагааг бэхжүүлэх (19,6%) дэлхий дахины эдийн засгийг эрүүл хөгжүүлэх (14,6%), глобал асуудлыг шийдэхэд хүчээ нэгтгэх чухал гэж үзсэн байна.
- ❖ Япон орны шинжлэх ухаан, технологийн хөгжлийн ирээдүйн хэтийн төлөвийн тухайд Монголчууд тун өөдрөг үзэлтэй байдгийг сэхээтний 77,9% нь Японы техник технологи өнөөгийнхөөс илүүтэйгээр дэлхийн хөгжилд эерэг нөлөөлөх болно гэж үздэг баримт нотолж байгаа юм. Эцэст нь Монголын олон нийт, түүний дотор сэхээтнүүд Япон улсаас олон улсын тавцанд чухал хувь нэмэр оруулж чадах салбар бол энх тайван, олон улсын аюулгүй байдал, эдийн засаг болон шинжлэх ухаан, технологийн салбар гэж үзэж байсныг онцлон тэмдэглэж байна.